



“ХҮРД” КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 08-р сарын 03-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Г

Т

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 61.1.2-д заасны дагуу хувьцаа эзэмшигч Э.Тэмүүжиний гаргасан санал шаардлагыг үндэслэн ТОГТООХ НЬ:
Нэг: Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны 09-р сарын 12-ны өдөр 14 цагаас зарлан хуралдуулсугай.

Хоёр: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг 2024 оны 08-р сарын 07-ны өдөр багтаан СЗХ-ны 377-р тогтоолын 3-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

Гурав: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал даргалагчаар ТУЗ-ийн дарга Б.Мөнхбатыг томилсугай.

Дөрөв: Хурал зохион байгуулах болон хурлын тооллогын комисст Ч.Саранзаяа Ж.Олонбаяр О.Шинэхүү нарыг томилсугай.

Тав: Хурлаар дараахь асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

Нэг: Хүрд ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Хоёр: Охин компанийн дүрмийн сан нэмэгдүүлэх тухай

Гурав: Охин компанийн гүйцэтгэх удирдлага томилох тухай

Дөрөв: Охин компанийн бизнес төлөвлөгөө батлах тухай

Тав: ТУЗ-ийн гишүүн чөлөөлөх, нөхөн томилох тухай.

Зургаа: Компанийн хагас жилийн тайлан, баланстай танилцах

Долоо: Компанийн хуулийн дагуу хэлэлцэх бусад асуудал

ТУЗ-ИЙН ДАРГА

Б.МӨНХБАТ

